



Баянзүрх дүүргийн статистикийн хэлтэс



Улаанбаатар хот

2017 он

АГУУЛГА

Нэр	Хуудас
Оршил	3
Нэг. ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	4
Хоёр. МАЛ БҮХИЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДГЭЭРИЙН СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ	7
Гурав. МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ	10
Дөрөв. ТЭЖЭЭВЭР АМЬТАД	18
Тав. ДҮГНЭЛТ	19

ОРШИЛ

Манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр суурь эзэлдэг билээ. Иймээс монгол улсын үндсэн хуульд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн газрын удирдамж зааврын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 дугаар сарын 7-17-ны өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж явуулдаг билээ.

Үүний дагуу дүүрэгт 2016 оны мал тооллогыг нийслэлийн Засаг даргын А/965 тоот захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2014 оны 12 дүгээр сарын 04-ны өдрийн А/611 тоот захирамжаар энэ оны мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах ажлын хэсэг байгуулж, ажиллах удирдамжийг батлуулан тооллогын хугацаанд амжилттай зохион байгуулж явууллаа.

Мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэсэн энэхүү судалгаа нь дүүргийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулахад суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

Нэг. ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Таван хошуу малыг бодод шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ – 1.5 бод
- 1 адуу – 1 бод
- 1 үхэр – 1 бод
- 6 хонь – 1 бод
- 8 ямаа – 1 бод

Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ – 5 хонь
- 1 адуу – 7 хонь
- 1 үхэр – 6 хонь
- 1 хонь – 1 хонь
- 1 ямаа – 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

- Тэмээ – 4 настай, 5 ба түүнээс дээш настай
- Адуу – 3 настай, 4 ба түүнээс дээш настай
- Үхэр – 2 настай, 3 ба түүнээс дээш настай
- Бог мал /хонь, ямаа/ - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

- Тэмээ – Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай
- Адуу – Өнгөрсөн жилийн төл, 2 настай
- Үхэр – Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт болон худалдаж авсан, шилжиж ирсэн мал, зарлага тал нь худалдсан, шилжүүлсэн мал болон хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 10-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

- 1 Буур – 20 ингэ
- 1 Азарга – 10 гүү
- 1 Бух – 25 үнээ
- 1 Хуц, ухна – 50-60 эм хонь, эм ямаа

Том малын зүй бусын хорогдолд: Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан гэх мэт) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны хангамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

- Хадлан өвс 0.45
- Таримал тэжээл 0.35
- Даршны ургамал 0.25
- Гар тэжээл, хужир шүү 1.0
- Үр тарианы хаягдал 0.9
- Лай 0.4
- Сүрэл 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна. Үүнд:

- Бүдүүн тэжээл – Өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс
- Хүчит тэжээл – Үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
- Шүүст тэжээл – бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал

Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно.

Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Хоёр. МАЛ БҮХИЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДГЭЭРИЙН СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МАЛ БҮХИЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО

2016 оны мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнгээр дүүргийн хэмжээнд 1193 өрх тоологдсон байна. Үүний 26.6 хувь буюу 318 өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 73.4 хувь буюу 875 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөж үржүүлж буй малтай өрх байна. Хүснэгт 1. Малчин, малтай өрхийн тоо 2012-2016 он


Үзүүлэлт	Хороо	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Малтай өрх	2-р хороо	1	1	1	1	2
	8-р хороо	1	1	4	3	3
	9-р хороо	51	51	37	37	45
	10-р хороо	9	6	2	4	3
	11-р хороо	305	228	201	240	286
	12-р хороо	3	2	1	1	4
	16-р хороо	-	1	-	-	-
	17-р хороо	10	3	-	-	-
	19-р хороо	3	-	-	-	-
	20-р хороо	668	631	653	696	799
	21-р хороо	7	6	4	7	11
	22-р хороо	1	-	-	-	-
	23-р хороо	20	20	18	18	26
	24-р хороо	3	-	-	4	3
	27-р хороо	1	1	2	1	1
28-р хороо	12	8	9	10	10	
Дүүргийн дүн		1095	960	933	1022	1193
Малчин өрх	9-р хороо	12	-	18	13	18
	10-р хороо	-	-	-	1	1
	11-р хороо	30	27	61	34	75
	20-р хороо	187	192	235	190	220
	21-р хороо	-	-	4	4	2
	23-р хороо	-	-	-	2	-
	24-р хороо	-	-	-	1	1
	28-р хороо	3	1	3	2	1
Дүүргийн дүн		232	220	321	247	318

2016 оны байдлаар мал аж ахуйн үйлдвэрлэлд 318 өрхийн 1055 ам бүл ажиллаж байна. Түүний 599 нь мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шимийг амьжиргааны эх үүсвэрээ болгон амьдарч байгаа малчид байна. Малчдыг насны бүлгээр авч үзвэл 10.0 хувь нь 16-34 насны, 81.8 хувь нь 35-59 насны, 8.2 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүмүүс байна.

Хүснэгт 2. Малтай болон малчин өрх, малчдын тоо 2012-2016 он

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Малтай өрх	1095	960	933	1022	1193
Түүний ам бүл	3343	2997	2828		
Малчин өрх	232	220	321	247	318
Түүний ам бүл	800	787	933	861	1055
Малчдын тоо	456	423	566	448	599
Үүнээс: -16-34 насны	74	113	92	61	60
-35-59 насны	307	296	424	360	490
-60 ба түүнээс дээш насны	75	14	50	27	49
Нийт малчдаас эмэгтэй	214	201	279	199	289
Насны бүтэц %	100	100	100	100	100
Үүнээс: -16-34 насны	16.2	16.7	16.3	13.6	10.0
-35-59 насны	67.3	69.9	74.9	80.3	81.8
-60 ба түүнээс дээш насны	16.5	16.5	8.8	6.0	8.2

Зураг 1. Малтай болон малчин өрх, малчдын тоо 2012-2016 он



Малчдын соёл, ахуйн үзүүлэлт: 2016 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор нийт малчин өрхийн 89.1 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 78.2 хувь нь сансарын антентай, 70.1 хувь нь телевизортой, 34.1 хувь нь радиотой, 55.5 хувь нь оёдлын машинтай, 97.3 хувь нь гар утастай, 5.0 хувь нь худагтай, 43.2 хувь нь автомашинтай, 4.5 хувь нь мотоциклтэй байна.

Зураг 2. Малчдын соёл, ахуйн үзүүлэлтүүд, 2014 он



Хүснэгт 3. Малчин өрхийн соёл, ахуйн зарим үзүүлэлтүүд, 2012-2016 он

	Өрхийн тоо					Малчин өрхийн тоонд эзлэх хувь				
	2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016
Цахилгаан эх үүсгүүртэй	186	196	292	235	229	80.2	89.1	91.0	95.1	72.0
Телевизортой	173	156	266	206		74.6	70.1	82.9	83.4	
Автомашинтай	91	95	95			39.2	43.2	30.0		
Мотоциклтой	19	10	10			8.2	4.5	3.1		

Цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо 2016 онд 292 болж, өмнөх оныхоос 96 буюу 49.0 хувиар, телевизортой өрхийн тоо 110 буюу 70.5 хувиар тус тус өссөн байна.

Гурав . МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

Малын тоо: 2016 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнгээр дүүргийн хэмжээнд 12 хороонд 1193 өрхийн 55319 толгойд хүрч өнгөрсөн оныхоос 5190 толгой малаар буюу 9.4 хувиар өсчээ.

Хүснэгт 3. Малын тоо, төрлөөр, 2010-2016 он

Малын төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2016/2015	
								Зөрүү	Хувь
Тэмээ	3	0	0	0	0	2	2	0	0.0
Адуу	3045	2531	2660	2819	4271	3856	5515	1659	30.1
Үхэр	11460	11172	12286	13463	15583	18558	18464	-94	-0.5
Хонь	11706	11057	11724	14015	13583	14546	17401	2855	16.4
Ямаа	12269	12785	12411	12677	12695	13167	13937	770	5.5
Бүгд	38483	37545	39081	42974	46132	50129	55319	5190	9.4

Энэ жилийн тооллогоор адуу 1659 буюу 30.1 хувиар, хонь 2855 буюу 16.4 хувиар, ямаа 770 буюу 5.5 хувиар тус тус өссөн бол үхэр 94 буюу 0.5 хувиар буурсан байна.

Нийслэлийн хэмжээнд 2016 оны мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнгээр 438.3 мянган толгой ба үүний 12.6 хувийг тус дүүрэг эзэлж байна.

Зураг 3. Дүүргийн малын тоо, мянган толгой, 2010-2016 он



Хүснэгт 4. Малын орлого, зарлага, төрлөөр, 2016 он


Төрөл	Оны эхэнд	Орлого			Зарлага				Оны эцэст
		Худалдаж авсан, шилжиж	Бэлэн тоологдсон төл	Худалдсан, шилжүүлсэн	Алдсан	Зах зээлд борлуулсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хорогдол	
Тэмээ	2								2
Адуу	3856	1576	974	416	19	189	188	79	5515
Үхэр	18558	2303	5376	3527	73	1910	1640	623	18464
Хонь	14546	4785	5440	3648	30	1896	1249	547	17401
Ямаа	13167	3855	3876	3906	4	1721	901	429	13937
Дүн	50129	12519	15666	11497	126	5716	3978	1678	55319

Дээрх хүснэгтээс харахад энэ жил бэлэн тоологдсон төл 15666 толгойгоор, худалдаж авсан, шилжиж ирсэн мал 12519 толгойгоор тус тус орлого талыг нэмэгдүүлж байхад харин бусдад худалдсан болон шилжүүлсэн малын тоо 11497 толгой, зах зээлд борлуулсан малын тоо 5716 толгой, хүнсэнд хэрэглэсэн малын тоо 3978 толгой, зүй бус хорогдол 1678 толгой болж зарлага талын гол үзүүлэлтийг тодорхойлж байна.

Малын сүргийн бүтэц: 2016 оны байдлаар нийт мал сүргийн 43.3 хувийг бод мал, 56.6 хувийг бог мал эзэлж байна.

Нийт сүрэгт адуу 10 хувь, үхэр 33.4 хувь, хонь 31.5 хувь, ямаа 25.2 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4. Мал тооллогын сүргийн бүтэц, 2016 он




Хүснэгт 5. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь, 2010-2016 Он

Малын төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүгд	100	100	100	100	100	100	100
Тэмээ	0.01	0	0	0	0	0.004	0.004
Адуу	7.9	6.7	6.8	6.6	9.3	7.7	10.0
Үхэр	29.8	29.8	31.4	31.3	33.8	37.0	33.4
Хонь	30.4	29.4	30.0	32.6	29.4	29.0	31.5
Ямаа	31.9	34.1	31.8	29.5	27.5	26.3	25.2

Дээрх хүснэгтээс харахад дүүргийн хэмжээнд тэмээн сүрэг сүүлийн 2 жилд огт байхгүй байснаа бодвол 0.004 хувь, адуун сүргийн хувийн жин харьцангуй хэвийн, үхэр сүрэг өмнөх оныхоос буурсан байна. Мөн бог малын хувьд хонин сүргийн хувийн жин сүүлийн 3 жилийн туршид өсөлт, бууралт нь хэвийн тогтвортой байгаа ба харин ямаан сүргийн хувьд өмнөх оныхоос буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 5. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь, 2013-2016 он



Малын тоо хороогоор: Малын тоог хороо тус бүрээр нь харахад 2016 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор дүүргийн нийт малын 80-аас дээш хувийг эзэлдэг 20 дугаар хороо нь 43791 толгой мал тоолуулсан ба 2015 оноос 3577 толгой малаар буюу 8.9 хувиар малын тоо толгой өссөн байхад бусад хороод нь малын төрөл тус бүрт бууралттай байна. Энэ нь 11, 20 дугаар хороодоос бусад хороод дээр мал эрхлэхийг хориглосон бүс байсан учир малыг албадан гаргасантай холбоотой юм.

Хүснэгт 6. Малын тоо, хороогоор, 2014-2016 он

Төрөл Он	Адуу			Үхэр			Хонь			Ямаа			Бүгд		
	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он
2-р хороо	-	-	-	3	4	5	-	-	-	-	-	-	3	4	5
8-р хороо	8	5	7	18	23	17	-	-	-	-	-	-	26	28	24
9-р хороо	20	16	65	407	450	617	304	422	826	539	434	644	1270	1322	2152
10-р хороо	2	2	1	48	118	64	-	-	-	-	-	-	50	118	65
11-р хороо	496	740	917	2334	3088	2988	642	1786	2249	672	1923	2258	4144	7539	8414
12-р хороо	-	-	-	12	17	-	-	-	-	-	-	-	12	17	-
20-р хороо	3725	3046	4460	12398	14362	14302	12586	12197	14186	11381	10609	10843	40090	40214	43791
21-р хороо	-	-	-	31	43	31	51	37	3	98	105	33	180	185	67
22-р хороо	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
23-р хороо	4	9	10	150	200	218	-	14	28	5	16	68	159	239	324
24-р хороо	-	3	-	-	14	8	-	90	109	-	80	91	-	187	208
27-р хороо	-	-	-	4	2	2	-	-	-	-	-	-	4	2	2
28-р хороо	16	35	55	178	239	212	-	-	-	-	-	-	194	274	267
НИЙТ	4271	3856	5515	15583	18558	18464	13583	14546	17401	12695	13167	13937	46132	50129	55319

Хувийн /амины/ малын тоо: 2016 оны мал тооллогоор амины малын тоо 55176 толгой болж нийт малын 99.7 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оныхоос 5197 толгой малаар буюу 10.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 7. Хувийн малтай өрх, малын тоо, 2010-2016 он

Он	Малтай өрх	Бүгд	Үүнээс:					1 өрхийн дундаж мал
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2010	1187	38165	3	3045	11460	11706	12269	32
2011	1117	37324	0	2531	11172	11057	12785	33
2012	1095	38609	0	2660	12286	11724	12411	35
2013	960	42640	0	2819	13463	14015	12677	44
2014	933	46054	0	4271	15583	13505	12695	50
2015	1017	49979	2	3851	18489	14470	13167	49
2016	1025	55176	2	5510	18410	17317	13937	54

2016 оны байдлаар 1 өрх дунджаар 54 толгой малтай болсон нь өнгөрсөн жилээс 10.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. Малтай өрхийн малын бүлэглэлт, 2014-2016 он

Малын бүлэглэлт	Өрхийн тоо			Дүнд эзлэх хувь			Малын тоо		
	2014	2015	2016	2014	2015	2016	2014	2015	2016
10 хүртэл малтай	317	344	341	33.9	33.8	33.3	1752	1970	1934
11-30 малтай	298	313	327	31.9	30.8	31.9	5447	5923	6152
31-50 малтай	111	121	126	11.9	11.9	12.3	4263	4751	4887
51-100 малтай	95	115	104	10.2	11.3	10.2	6604	8058	7627
101-200 малтай	59	58	51	6.3	5.7	5.0	8321	8071	7426
201-500 малтай	44	60	65	4.7	5.9	6.3	12803	17526	19850
501-999 малтай	9	6	10	1.1	0.6	1.0	6864	3680	6280
Бүгд	933	1017	1024	100	100	100	46054	49979	54156

2016 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоны дүнгээс малын бүлэглэлт тус бүрээр авч үзэхэд 10 хүртэлх толгой малтай 1 өрхөд 5.7 толгой мал, 11-30 малтай 1 өрхөд 18.8 толгой мал, 31-50 малтай 1 өрхөд 38.8 толгой мал, 51-100 малтай 1 өрхөд 73.3 толгой мал, 101-200 малтай 1 өрхөд 145.6 толгой мал, 201-500 малтай 1 өрхөд 305.4 толгой мал, 501-999 малтай 1 өрхөд 628 толгой мал тус тус ноогдож байна.

Хээлтэгч мал: 2016 оны эцэст 27122 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 3008 толгойгоор буюу 4.79 хувиар өссөний дотор гүү 572 толгой, үхэр 216 толгой, эм хонь 1654 толгой, эм ямаа 566 толгойгоор тус тус өссөн байна.


Хүснэгт 9. Хээлтэгч малын тоо, төрлөөр, 2010-2016 он

Малын төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2016/2015	
								Зөрүү	Хувь
Тэмээ	1	0	0	0	0	0	0	0	0
Адуу	982	832	834	856	1178	1252	1824	572	1.46
Үхэр	5858	5854	6132	6361	7312	8660	8876	216	1.02
Хонь	6556	5532	6159	7201	6994	7557	9211	1654	1.22
Ямаа	7521	6572	6370	6578	6608	6645	7211	566	1.09
Бүгд	20918	18790	19495	20996	22092	24114	27122	3008	4.79

Хээлтэгч мал нийт малын 49 хувийг эзэлж байна.

Үүнд:

- ❖ Адуун сүргийн – 33.1 хувь
- ❖ Үхэр сүргийн – 48.1 хувь
- ❖ Хонин сүргийн – 52.9 хувь
- ❖ Ямаан сүргийн – 51.7 хувь



Зураг 6. Хээлтэгч малын тоо

Хүснэгт 10. Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд, 2010-2016 он

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2016/2015	
								Зөрүү	Өсөлтийн хурд
Бэлэн тоологдсон төл	8992	12078	12273	13468	13787	15732	15666	-66	1.00
Том малын зүй бус хорогдол	6796	441	127	428	308	377	1678	1301	4.45
Хээлтэгч малын тоо	20918	18790	19495	20996	22092	24114	27122	3008	1.12
Хээл хаясан хээлтэгч	778	57	60	187	426	311	122	-189	0.39
Сувайрсан хээлтэгч	1977	2548	611	2065	4632	3850	5423	1573	1.41

2016 оны мал тооллогын дүнгээс харахад бэлэн тоологдсон төл 66 толгой мал буюу 0.4 хувиар, Хээл хаясан хээлтэгч 189 толгой мал буюу 0.39 дахин буурсан хэдий ч, том малын зүй хорогдол 1301 толгой мал буюу 4.45 дахин, хээлтэгч малын тоо нь 3008 толгой мал буюу 1.12 дахин, сувайрсан хээлтэгч нь 1573 толгой мал буюу 1.41 дахин өссөн байгаа эдгээр үзүүлэлт нь малын өсөлтөнд эерэгээр нөлөөлсөн байна.

Хүснэгт 11. Бойжуулсан төл, 2010-2016 он

Малын төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2016/2015	
								Зөрүү	Хувь
Ботго	-	-	-	-	-	-	-	-	-
Унага	307	455	454	524	720	716	974	258	36.03
Тугал	3347	3174	4058	4316	4771	5805	5376	-429	-7.39
Хурга	3135	4126	4007	4776	4536	5010	5440	430	8.58
Ишиг	2203	4323	3754	3852	3760	4201	3876	-325	-7.74
Бүгд	8992	12078	12273	13468	13787	15732	15666	-66	-0.42

2016 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор бойжуулсан төлийн тоо 15666 толгой болж өнгөрсөн оныхоос 66 толгойгоор буюу 7.7 хувиар буурсан байна. Бойжуулсан төлийн тоо өнгөрсөн онтой харьцуулахад унага, хурга өссөн үзүүлэлттэй байхад тугал, ишиг нь буурсан үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн 2015 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор 24114 хээлтэгч төллөхөөр тоологдсон бөгөөд:

- ❖ Хээлтэй малын орлогоор 5251 толгой мал нэмэгдэж
- ❖ Хээлтэй мал нь 5514 зарлагдаж
- ❖ Хээл хаясан 122 толгой мал
- ❖ Сувайрсан 5423 толгой мал тус тус хасагдаж нийт 18306 хээлтэгч төллөсөн байна.

Хүснэгт 12. Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр, 2016 он

Малын төрөл	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан, шилжиж ирсэн	Худалдсан, шилжүүлсэн
Унага	1252	1185	214	971	3	0
Тугал	8660	5729	338	5391	16	31
Хурга	7557	6197	832	5365	86	11
Ишиг	6645	5207	1364	3843	62	29
Бүгд	24114	18318	2748	15570	167	71

Том малын зүй бус хорогдол: 2016 оны тооллогоор 1678 том мал хорогдсон бөгөөд өнгөрсөн оныхоос 1301 толгойгоор буюу 4.5 дахин өссөн байна. Нийт хорогдсон малын 4.7 хувийг адуун сүрэг, 37.1 хувийг үхэр сүрэг, 32.6 хувийг хонин сүрэг, 25.6 хувийг ямаан сүрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 13. Том малын зүй бус хорогдол, 2010-2016 он

Малын төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2015/2016	
								Зөрүү	Өсөлтийн хувь
Адуу	215	49	24	29	16	51	79	28	1.5
Үхэр	627	133	42	89	73	151	623	472	4.1
Хонь	2626	129	36	164	98	77	547	470	7.1
Ямаа	3328	130	25	146	121	98	429	331	4.4
Бүгд	6796	441	127	428	308	377	1678	1301	4.5

2016 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор нийт хорогдсон малын 81 толгой мал буюу 4.8 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

Дөрөв. ТЭЖЭЭВЭР АМЬТАД

2016 онд дүүргийн хэмжээнд 57 өрхөд нийт 652 гэрийн тэжээвэр амьтад тоологдсон бөгөөд дийлэнх нь буюу 63 хувийг шувуу эзэлж байна.

Хүснэгт 14. Тэжээвэр амьтад, төрлөөр, 2011-2016 он

Тэжээвэр амьтдын төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2016/2015
	Зөрүү						
Гахай	1039	1160	2465	711	370	202	-168
Шувуу	6416	552	470	329	332	412	80
Цаа	-	1	1	-	-	-	-
Илжиг	-	1	-	-	1	-	-1
Туулай	34	57	34	30	10	7	-3
Минж	-	23	23	-	-	31	31
Зөгийн бүл		-	-	10	46	-	-46
Нийт	7489	1794	2993	1102	759	652	-107

Хүснэгт 15. Тэжээвэр амьтдын тоо, хороогоор, 2016 он

2016 онд дүүргийн нийт 28 хороонд гэрийн тэжээвэр 18547 нохой, 470 муур байна. Тэжээвэр муур, нохойны бүртгэлийн дүнг өмнөх оны дүнтэй харьцуулахад нохой 2669 буюу 16.8 хувиар өсч, муур 101 буюу 27.3 хувиар өсчээ.

Хороо	Нохой	Муур	Гахай	Шувуу	Үүнээс: Тахиа	Туулай	Минж
1-р хороо	54	2	0	0	0	0	0
2-р хороо	483	10	0	0	0	0	0
3-р хороо	19	2	0	0	0	0	0
4-р хороо	422	13	0	0	0	0	0
5-р хороо	1925	53	0	0	0	0	0
6-р хороо	9	2	0	0	0	0	0
7-р хороо	16	1	0	0	0	0	0
8-р хороо	658	2	0	0	0	0	0
9-р хороо	1530	15	16	71	38	2	0
10-р хороо	315	12	0	0	0	0	0
11-р хороо	1051	12	44	42	18	0	0

12-р хороо	712	21	0	64	64	4	0
13-р хороо	137	0	0	0	0	0	0
14-р хороо	52	0	0	0	0	0	0
15-р хороо	13	0	0	0	0	0	0
16-р хороо	115	0	0	0	0	0	0
17-р хороо	1210	19	0	0	0	0	0
18-р хороо	31	3	0	0	0	0	0
19-р хороо	2363	0	0	0	0	0	0
20-р хороо	95	149	69	124	45	0	31
21-р хороо	1720	18	9	54	47	1	0
22-р хороо	463	18	0	0	0	0	0
23-р хороо	3204	0	39	37	32	0	0
24-р хороо	517	3	25	0	0	0	0
25-р хороо	19	2	0	0	0	0	0
26-р хороо	24	0	0	0	0	0	0
27-р хороо	610	0	0	0	0	0	0
28-р хороо	780	113	0	20	12	0	0
Нийт	18547	470	202	412	256	7	31

ДҮГНЭЛТ

2011 оноос хойшхи мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнгээс харахад дүүргийн малын тоо өссөн үзүүлэлттэй байна. Харин энэ өсөлт нь 11, 20 дугаар хороодод түлхүү байгаа ба бусад хороодод мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс малтай өрхийг нүүлгэн шилжүүлж, дээрх 2 хороодод малтай өрх байхыг зөвшөөрсөнтэй холбоотой юм. Гэтэл 2016 оны “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ын дүнгээр 55319 толгой мал тоолуулж 5190 толгой мал буюу 10.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тус дүүргийн нийт малын 80-аас дээш хувийг эзэлдэг 20 дугаар хороонд малын сүрэг тус бүр дээр өссөн учраас дүүргийн өсөлтөнд нөлөөлж байна.

Дүүргийн хэмжээнд мал, тэжээвэр амьтад бүхий 11 хорооны 1 аж ахуйн нэгж байгууллага, 1021 өрхийн 55319 толгой мал тоологдсныг төрөл тус бүрээр авч үзвэл:

- ❖ Адуу – 5515
- ❖ Үхэр – 18464
- ❖ Хонь – 17401
- ❖ Ямаа – 13937 толгой малтай байна.

Бог малын бүтцэд 2016 оны байдлаар бог малын 55.5 хувийг хонин сүрэг, 44.5 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

2016 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор амины малын тоо 55176 толгой болж нийт малын 99.7 хувийг эзэлж байна.

Дүүргийн хэмжээнд өрх, аж ахуйн нэгж байгууллагын нийт гахай 202, шувуу 412, туулай 7, минж 31, нохой 18547, муур 470 тус тус тэжээвэр амьтад тоологдсон болно.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Нэгтгэн боловсруулсан мэргэжилтэн:

Х. Намуунзул

Хянасан хэлтсийн дарга:

Э. Энхтунгалаг

Цахим хаяг: www.nso.mn

www.1212.mn

www.ubstat.mn

E-mail: bayanzurkh@nso.mn

Утас: 267349, 261728, 261019